



**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАР**

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-51) 26 20 46, Факс: (976) 7015 2046,
Цахим шуудан: info@ags.gov.mn,
Цахим хуудас: www.ags.gov.mn

2024.04.10 № 01/293
танай _____-ны № _____-т

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ц.БАЯРБАТ ТАНАА**

Зөвлөмж хүргүүлэх тухай

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд тус тус заасны дагуу Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, хөтөлбөр, төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдаан, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар тус тус хэлэлцүүлэв.

Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт 2023 оны дүнгээр 80.4 хувь, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 2020-2023 оны дүнгээр 73.8 хувь, Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний биелэлт 79.2 хувьтай байна.

Үндэсний аудитын газраас Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланд аудит хийж, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 70.5 хувь, Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний биелэлтийг 70.8 хувь гэж үнэлсэн.

Түүнчлэн аудитын дүнгээр хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь болон хүрэх түвшин, санхүүжилтийн эх үүсвэр, санхүүжилтийн хэмжээг бодитой тодорхойлоогүй, төлөвлөгөөний төсөлд төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжээс санал авах, иргэд олон нийтээр хэлэлцүүлэх асуудал хангалтгүй, хяналт-шинжилгээ, үнэлгээг арга хэмжээний хэрэгжилтийн тайланд үндэслэсэн, нотлох баримтыг цахим системд оруулж хэвшээгүй, хяналтын тогтолцоо сул, хөтөлбөрийн үр дүнд бий болсон бүтээн байгуулалт, түүнд зарцуулсан хөрөнгийг нэгтгэн тайлагнаагүй, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад босоо болон хэвтээ тогтолцоондоо төрийн захиргааны төв байгууллага хамтарч ажиллах зохион байгуулалтын арга хэмжээ хэрэгжүүлээгүй, бодлогын баримт бичгийг

Боловсруулсан: *А. Наранг*
Хянасан: *Б. Агваарца*
Хувь: *А*

хэрэгжүүлснээр нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг үнэлэх эрх зүйн зохицуулалт дутагдалтай байна гэж дүгнэсэн байна.

Дээрх бодлогын баримт бичигт тусгагдсан Барилга, хот байгуулалтын яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс авч үзвэл:

1.Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн Хүний хөгжил, Амьдралын чанар ба дундаж давхарга, Эдийн засаг, Бүс, орон нутгийн хөгжил, Улаанбаатар ба дагуул хот бодлогын хүрээнд Барилга, хот байгуулалтын яамны хариуцсан болон хамтран хэрэгжүүлэх 24 арга хэмжээ тусгагдсанаас 11 арга хэмжээ “үр дүнтэй”, 7 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 5 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай”, 1 арга хэмжээ “үр дүнгүй” үнэлэгдэж, хэрэгжилт дунджаар 77.5 хувь байна. Дараах 6 арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

- [2.5.3] Агаар, ус, хөрсний бохирдол болон дуу чимээг багасгаж, цэвэр, ногоон байгууламж бүхий орчныг нэмэгдүүлнэ.
- [3.6.3] Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын систем бий болж, газрыг хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлнэ.
- [4.2.7] Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн эрчим хүч, инженерийн дэд бүтцийг хөгжүүлнэ.
- [8.1.10] Аймаг, сумын төвийг бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамруулж, сумдад “Сумын хөгжил” арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- [9.5.1] Олон төвт хотын тогтолцоог хэрэгжүүлж, “Шинэ Зуунмод”, “Майдар” шинэ дагуул хотын бүтээн байгуулалтыг эхлүүлж, инженерийн шугам сүлжээ, орон сууцжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлсэн байна.
- [9.5.4] Дагуул хотуудад дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

2.Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Барилга, хот байгуулалтын яамны үндсэн хариуцах 69, хамтран хэрэгжүүлэх 37 арга хэмжээ тусгагдсан. Үндсэн хэрэгжүүлэх 69 арга хэмжээнээс 13 арга хэмжээ “үр дүнтэй”, 34 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 22 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай” үнэлэгдэж, нийт арга хэмжээний хэрэгжилт 2020-2023 оны дүнгээр 75.5 хувь байна.

Эдийн засаг, Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд тусгагдсан дараах 22 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- [3.7.1.5] Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж батлуулна.
- [3.7.2.1] Улсын хэмжээнд хот суурингийн төвийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг, газар доорх шугам сүлжээний зургийг солбицлын ITRF2020 эринд шилжүүлэх ажлыг зохион байгуулна.

- [3.7.2.2] Навигацын хиймэл дагуулаас мэдээ хүлээн авах суурин станц /GNSS/-ыг өргөжүүлэх замаар байрлалын сүлжээний нарийвчлалыг 2 см хүртэл сайжруулж, геодезийн хэмжил, зураглалын үйл ажиллагаанд ашиглана.

- [3.7.2.3] Батлан хамгаалах, газар зохион байгуулалт, хот байгуулалт, геологи хайгуул, байгаль орчин, авто зам, төмөр зам зэрэг салбарын эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000 масштабтай байр зүйн зургаар зурагжуулна.

- [3.7.2.4] Монгол Улсын өндрийн тулгуур сүлжээг шинэчилж өндрийн сүлжээний нарийвчлалыг сайжруулна.

- [3.7.2.5] Улсын хэмжээнд хаягийн мэдээллийн нэгдсэн системийг байгуулж, хэрэглээнд нэвтрүүлнэ.

- [3.7.3.2] Хиймэл оюун ухаан, блокчейн болон газар зүйн мэдээллийн системд суурилсан гурав болон дөрвөн хэмжээст газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлнэ.

- [3.7.3.3] Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн суурь өгөгдлийг бүрдүүлэх, мэдээллийн нэгдсэн системийг бүрэн ашиглалтанд оруулж, хэрэглээнд нэвтрүүлнэ.

- [3.7.3.6] Геоорталаар дамжуулан төрийн бодлого, төлөвлөлт, шийдвэр гаргалтын "Нэг газрын зураг", иргэд, олон нийт, бизнесийн зориулалттай "Нээлттэй газрын зураг" цахим үйлчилгээг улсын хэмжээнд нэвтрүүлнэ.

- [3.7.3.7] Улсын хэмжээнд ашиглагдаж буй барилга, байгууламжийн паспортжуулалт, тэдгээрийн чанар, насжилтыг тодорхойлж, цахим мэдээллийн нэгдсэн санд үнэлгээг оруулна.

- [3.7.3.8] Аймаг, сум, суурин газруудын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн бичил мужлалын зураглал хийх, газар хөдлөлтийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, техникийн судалгааны ажлын хийж дуусган, мэдээллийн нэгдсэн санд оруулна.

- [3.7.4.6] Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг бий болгож, газрыг хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлэн хяналт тавина.

- [3.7.8.1] Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци байгуулах хууль, эрх зүйн орчинг бүрдүүлж, корпорацийг шинээр байгуулна.

- [3.7.9.1] Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороонд "Ногоон нуур 1008 айлын орон сууц төсөл"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

- [3.7.9.2] "Солонго 1", "Солонго 2" төслүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

- [3.7.9.3] "Баянголын амны орон сууц" барих төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

- [3.7.9.4] Орлогод нийцсэн 10,000 орон сууцны эко хорооллын төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

- [3.7.9.5] Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хороонд орлогод нийцсэн 740 айлын орон сууцны төсөл хэрэгжүүлнэ.

- [3.7.11.6] Аймгийн төв, суурин газрын 8 цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих төслийг үе шаттай хэрэгжүүлнэ. /Баян-Өлгий, Дорнод,

Говьсүмбэр, Завхан, Увс, Говь-Алтай, Баянхонгор аймгуудын төв болон Улаанбаатар хотын Багануур дүүрэг/

- [3.7.12.4] Аймгийн төвүүдэд үерийн хамгаалалтын барилга, байгууламж барих ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- [6.2.7.2] Сумын хөгжил арга хэмжээг хэрэгжүүлж, инженерийн дэд бүтцийг барьж байгуулна.
- [6.2.11.1] Сумын хөгжил төслийн хүрээнд сумдад нийтийн халуун усны болон ахуйн үйлчилгээний төвийг ашиглалтад оруулна.

3.Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд Барилга, хот байгуулалтын яамны хариуцан хэрэгжүүлэх 5 арга хэмжээ, 15 шалгуур үзүүлэлт тусгагдсанаас хэрэгжилт 82.7 хувь байна. Хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэлэгдсэн дараах 2 арга хэмжээний 2 шалгуур үзүүлэлт байна. Үүнд:

1/ Боомтуудыг холбох төмөр зам болон авто зам барих хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх:

- “Солонго-1”, “Солонго-2” орон сууцны хороолол барих төслийн явц, хувиар;

2/ Орон нутаг дахь сум, суурин газрын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх:

- “Сумын хөгжил” арга хэмжээний хүрээнд инженерийн дэд бүтэц байгуулах сумын тоо.

Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн, аудитын дүгнэлтийг үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Зөвлөмж болгож байна:

1.Үндэсний аудитын газраас Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт 2024 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн дотор monitoring@ags.gov.mn цахим шуудангаар ирүүлэх;

2.Барилга, хот байгуулалтын яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах дээр дурдсан эрчимжүүлэх шаардлагатай, үр дүнгүй арга хэмжээний хэрэгжилтийн явцын байдалд дүн шинжилгээ хийж, хэрэгжүүлэх болон шийдвэрлэх боломжгүй арга хэмжээ, түүний шалтгаан нөхцөлийн талаар тайлбар, саналыг нотлох баримтын хамт Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлэх;

3.Тодорхой үр дүнд хүрсэн арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангах, эрчимжүүлэх шаардлагатай, үр дүнгүй арга хэмжээний хэрэгжилтийг хангах арга хэмжээг шуурхай зохион байгуулах, 2024 оны хэрэгжилт, үр дүнг сар бүр Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд тайлагнах;

4.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.5-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг тухайн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх” гэж заасны дагуу Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг бусад төлөвлөлтийн баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөж, 2024, 2025 онд хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг батлах;

5.Хөгжлийн дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийн төлөвлөлтийн явцад Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас үнэлгээ хийж, хөгжлийн бодлого, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэгцээ, шаардлагад тулгуурлан бодит нөөцөд үндэслэн оновчтой, харилцан логик уялдаа, хамааралтай төлөвлөж байгаа эсэх, дунд, богино хугацаанд улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд бодлогын төлөвлөлт харилцан уялдаатай эсэх, гүйцэтгэлийн болон хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг бүрэн, оновчтой тодорхойлсон эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгч ажиллах;

6.Бодлогын баримт бичигт тусгагдсан үндсэн хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг холбогдох яам, байгууллагатай хамтран зохион байгуулж, хэрэгжилт, үр дүнг нэгтгэн тайлагнаж байх;

7.Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланд тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгө, эх үүсвэрийн талаарх мэдээллийг тусгаж, Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд тоон мэдээллийг оруулах;

8.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнгийн тайлан, мэдээллийг нягтлан шалгаж, нотлох баримтаар баталгаажуулж, Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд оруулж байх.

ДАРГА  Б.БААСАНДОРЖ

9023010228 CTC3950 6975747